



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Оюутны шигшээ багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай


Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 18.6, 18.7 дахь заалт, Засгийн газрын 2005 оны 189 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/118 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын Боксын холбоо, Монголын гимнастикийн холбооны саналыг үндэслэн Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Оюутны шигшээ багийн боксын тамирчин Халингийн Бекнур, гимнастикийн тамирчин Пүрэвдоржийн Отгонбат нарыг үүрэгт ажлаас нь чөлөөлж, боксын тамирчин Мэндсайхны Батбаяр, гимнастикийн тамирчин Алтансүхийн Энхтулга нарыг тус тус томилон ажиллуулсугай.

2. Оюутны шигшээ багийн тамирчин Х.Бекнур, П.Отгонбат нартай холбогдох тооцоог хийж дуусгах, М.Батбаяр, А.Энхтулга нарыг тус тус 2016 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 200.000 /хоёр зуун мянган/ төгрөгөөр цалинжуулахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-т зөвшөөрсүгэй.

3. Оюутны шигшээ багийн боксын тамирчин М.Батбаяр, гимнастикийн тамирчин А.Энхтулга нартай 2016 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн гэрээ байгуулж, сургалт, дасгалжуулалтыг батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу чанартай зохион байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Оюутны шигшээ багийн ахлах дасгалжуулагч /Ө.Рагчаадорж/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

“2016” А Tushaal A4

1150500037